



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/47

Уужим төв

Газар эзэмшүүлэх эрхийн цахим дуудалга  
худалдаа зарлах тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудалга худалдаа явуулах журам”-ын 10.1.4, 10.2 дахь заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан газар эзэмших, ашиглах эрхийн дуудалга худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал, Сагсай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 51 дүгээр тогтоолоор баталсан газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 2 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг 2023 оны 06 дугаар сарын 23-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.
3. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг захирамж гарсан өдрөөс эхлэн 30-аас доошгүй хоног олон нийтэд, ил тод мэдээлэн зарлаж, дуудлага худалдааны бэлтгэл ажлыг ханган зохих журмын дагуу зохион байгуулахыг сумын Газрын даамал (Д.Нуржанат) –д даалгасугай.

ДАРГА  БАУЫРЖАН

